

ШХАБ-ЫН 10 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Казахстан улсын Алма-Ата хотноо 2011.02.22-23-нд “Аюулгүй байдал, хамтын ажиллагааны 10 жилийн замнал: ШХАБ-ын орон зай дахь орчин үеийн сорилтууд, аюул заналын эсрэг амжилттай хэрэгжүүлсэн туршлага” /10 лет по пути безопасности и сотрудничества: успешный опыт противодействия современным вызовам и угрозам на пространстве ШОС/ сэдэвт олон улсын эрдэм шинжилгээ-практикийн бага хурал болж өнгөрлөө. Энэхүү бага хурлыг Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/-ыг 2010-2011 онд удирдаж буй Казахстан улсын санаачлагаар 2011.06.15-нд Астана хотод болох тус байгууллагын 10 жилийн ойн дээд хэмжээний уулзалтанд бэлтгэх ажлын хүрээнд зохион байгуулсан юм. Гол зорилго ШХАБ туулж өнгөрүүлсэн 10 жилийн хугацаандаа аюулгүй байдлын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тоймлон дүгнэхийн зэрэгцээ ирэх 6-р сарын дээд хэмжээний уулзалтын төгсгөлийн баримт бичгүүдэд тусгаж болохуйц санал, зөвлөмжүүдийг тодруулах явдал байв.

Хурлын гол зохион байгуулагчаар БНКаЗУ-ын Гадаад хэргийн яам, Үндэсний аюулгүй байдлын хороо, Онцгой байдлын яам, Стратегийн судалгааны хүрээлэн, Дэлхийн улс төр, эдийн засгийн хүрээлэн болон ШХАБ-ын Нарийн бичгийн дарга нарын газар ба Бүс нутгийн терроризмтай тэмцэх бүтцийн Гүйцэтгэх хороо /Исполнительный комитет Региональной антитеррористической структуры ШОС/ зэрэг байгууллагууд ажиллалаа. Тус хуралд гишүүн 6 орон, ажиглагч 4 орон (Энэтхэг, Иран, Пакистан, Монгол), яриа хэлэлцээний түнш 2 орон (Беларус, Шри-Ланка), мөн Афганистан, Туркменистаны төр засгийн болон эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөгчид уригдан оролцсон нь хурлын цар хүрээг ихэд өргөтгөсөн төдийгүй эрдэм шинжилгээний хурал илүү нээлттэй, илэн далангүй хэлэлцэх, мэтгэлцэх бүтээлч нөхцөлд явагдах бололцоог бүрдүүлж байв. Монголын талаас тус хуралд Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын дэд захирал Б.Ерөөлт, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Д.Шүрхүү нар уригдан оролцсон ба доктор Д.Шүрхүү “ШХАБ дахь Монголын оролцоо ба хэтийн төлвийн талаарх үзэл бодол” сэдэвт илтгэл тавьсан болно. Мөн Алм-Ата хотноо сууж буй манай консул Р.Азбаяр зочноор оролцлоо.

Эрдэм шинжилгээний хурал 2 өдөр үргэлжлэх явцдаа нээлт, хаалтын нэгдсэн хуралдаанаас гадна “Бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад ШХАБ-ын үүрэг, байр суурь”, “ШХАБ-ыг өргөжүүлэх хэтийн төлөв ба олон улсын харилцааны цаашдын хөгжил”, “ШХАБ-ын орон зай дахь хар тамхины аюул өсөх хүчин зүйлс”, “ШХАБ-ын орон зай дахь шинэ аюул, сорилтууд” гэсэн 4 сэдвээр хийсэн салбар хуралдаанууд дээр эрдэмтэн судлаачид, дипломатууд, шинжээчид тус тусын үзэл бодол, байр суурь, таамаглалаа дэвшүүлж санал шүүмжлэл өрнүүлэв.

Тус хурал дээр хэлэлцсэн гол гол сонирхолтой асуудлуудыг товчлон дурдвал:

Бүс нутгийн аюулгүй байдлыг хангах асуудал. Хэдийгээр ШХАБ-ын хүрээнд “гурван аюул”-тай тэмцэх хууль эрх, зохион байгуулалтын үндэс суурь бэхэжсэн боловч шинэ аюул, шинэ нөхцөл байдал гарч ирж буйг илтгэгчид онцлон тэмдэглэв. Шашин, ядуурал, шинэ технологи, үндсэрхэх үзлийг алан хядагчид ашиглах болсоны дээр илүү харгис /амиа золиослох, олон хүнийг хөнөөх/, зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй болж байна. Мөн ШХАБ-ын орон зай, ойр орчмын бүс нутгуудын орнууд дахь дотоодын нийгмийн мөргөлдөөн, шашин угсаатны зөрчил, хар тамхи, хүн, зэвсгийн наймаа байдлыг улам хүндрүүлж, ШХАБ-ын аюулгүйн механизм /Киргизийн жишээ дээр/ бодит амьдрал дээр чадваргүй буюу бараг нөлөөгүй болох нь харагдсан. ОХУ-ын /МГИМО-гийн дэргэдэх/ Зүүн Ази, ШХАБ судлах төвийн захирал А.Лукин терроризмтой тэмцэх үед дотоод гадаад асуудлыг хэрхэн зааглах вэ гэсэн төвөгтэй асуулт тавьсанаар хэлэлцүүлэг нэлээд сонирхолтой өрнөсөн юм. Зарим хүмүүс Түвдийн салан тусгаарлах хөдөлгөөн, Домодедовогийн халдлагыг жишээ татан дотоод гадаад хэмээн ялган салгах боломжгүй гэсэн байр суурьтай байхад зарим нь эдгээр нь улс орны дотоод асуудал гэж үзэж байв. Казахстаны Стратегийн судалгааны хүрээлэнгийн шинжээч К.Сыроежкин гадаад хүчин зүйлээс дотоодынх илүү их хэмээн үзээд, Киргиз, Тажик болон арабын орнуудад болж буй үймээний гинжин нөлөөг жишээ татав. Тэрбээр хэрэв улс төрийн хүчнүүд байр сууриа баттай эзлэхгүй бол лалын шашны байгууллагууд орон зайг эзлэх болно, ШХАБ-ын болон гишүүн орнуудын удирдагчдын нэр хүндийг дээшлүүлэх шаардлагатай, мөн АНУ бүс нутгийн аюулгүй байдлын менежерийн үүрэг гүйцэтгэж байна гэсэн дүгнэлтүүд хийж байв. Терроризмыг хэрхэн үзэх, тэмцэх арга хэлбэрийн хувьд ч үзэл бодол янз бүр байв.

Зарим судлаачид ШХАБ бол гадны халдлагаас гишүүн орнуудаа хамгаалах зорилготой тусгай анги нэгтгэл бүхий ОКДБ /Организации Договора о коллективной безопасности/ маягийн цэргийн эвсэл холбоо биш гагцхүү терроризм, гэмт хэрэгтэй тэмцэх хүчний байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлж, зөвхөн тэр чиглэлээр гэрээ, програм боловсруулж, хээрийн сургууль хийгдэж байна гэжээ.

ШХАБ-ыг өргөжүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудал. Энэхүү хурлын нэлээд сонирхол татсан асуудлын нэг бол хамгийн түрүүнд ямар орон, хэзээ, ямар шалгуур болзлыг хангаж ШХАБ-ын шинэ гишүүн болох вэ гэдэг асуудал байв. Албан ёсоор Пакистан, Иран элсэх хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд 2010 оны Ташкентын дээд хэмжээний уулзалтаар батлагдсан шинэ гишүүн элсэхэд тавих шалгуур үзүүлэлтүүдээр НҮБ-ын хоригтой байгаа Иран тэнцэхгүй байдалд ороод байгаа. ОХУ-ын хувьд улс төр, эдийн засгийн хувьд нөлөө бүхий орон Энэтхэг хамгийн боломжтой орон гэсэн бол Хятад аажимдаа Афганистаныг элсүүлэх саналаа илэрхийлж байв. Ираны тал Төв Азийн аливаа асуудлыг Ирангүйгээр шийдвэрлэхэд хэцүү гэж мэдэгдсэн ШХАБ-д Ираныг элсэх асуудлыг хойшлуулах, Ираны

цөмийн асуудлыг ШХАБ-тай холбохгүй байхыг эрмэлзэж буй гишүүн орнуудын оролдлогыг далдуур шүүмжилж буй байдал ажиглагдаж байв. Хурлын орчуулга нэлээд доогуур, түүний дотор ираны төлөөлөгч үг хэлэх үед техникийн саатал болон перс /фарс/ хэлний орчуулга үе үе гацаж байсан нь түүний байр суурийг бүрэн ойлгоход хүндрэлтэй байв. Ерөнхийдөө шинжээчдийн дунд ШХАБ бол нээлттэй олон улсын байгууллага тул шинэ гишүүн элсүүлж, нэр хүндээ дээшлүүлэх хэрэгтэй гэсэн үзэл бодол бүхий нэг хэсэг байхад ШХАБ-ыг өргөжүүлэх нь удирдлага зохион байгуулалтад нэлээд хүндрэл бэрхшээл учруулж болзошгүй тул уг асуудлыг нэг хэсэгтээ хүлээнэх хэрэгтэй гэсэн байр суурийг өөр нэг хэсэг нь илэрхийлж байв. Мөн түүнчлэн асуудлын мөн чанар ШХАБ өөрөө гишүүнчлэлээ өргөжүүлэхэд бэлэн биш байна уу, эсвэл шинээр гишүүн элсэх орнууд шалгуур хангахгүй байна уу, эсвэл тухайн бүс нутаг, улс орнуудын дотоод асуудал, бүр тодруулбал ШХАБ Иран, Өмнөд Ази дахь нарийн төвөгтэй асуудалд хутгалдахыг хүсэхгүй байна уу гэдэгт байгаа бололтой. Хуралд оролцогчид Энэтхэгийн талаас албан ёсоор элсэх хүсэлтээ гаргасан эсэхийг тодруулахад, энэтхэгийн тал бид ШХАБ-д элсэхийг ихээхэн сонирхож буйгаа удаа дараа мэдэгдэж буй боловч шинэ гишүүн элсэх дүрэм журам, дэг, хууль эрхийн бичиг баримтууд эцсийн байдлаар гарсаны дараа албан ёсны хүсэлтээ гаргах эсэхээ шийдвэрлэнэ хэмээн мэдэгдэв.

Монгол Улсын хувьд ШХАБ-ын тэлэх асуудлыг хэрхэн үзэж буй талаар доктор Д.Шүрхүү судлаачийн байр сууринаас хэд хэдэн үндэслэл гарган тайлбарлав. Тэрбээр гадны шинжээчид Монголыг ШХАБ-ын шинэ гишүүн болох хамгийн боломжтой орны тоонд оруулдаг боловч бодит байдал дээр бүрэн эрхэт гишүүнээр элсэх нөхцөл хараахан бүрдээгүй хэмээн үзсэн. Үүнд гадаад, дотоод хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна. Гадаад хүчин зүйлийн хувьд Төв Азийн улс төр, аюулгүй байдлын нөхцөл байдал улам бүр тогтворгүй, зөрчил мөргөлдөөн гарах потенциал жилээс жилд нэмэгдэж байна. Дотоодын үймээн самуун нэмэгдэх, террорист халдлага, шашин-үндэстэн хоорондын зөрчил болон их гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөн ширүүсч байгаа нь биднийг хүлээнэхэд хүргэж байна. Гадаад хүчин зүйлийн дотор Монголын хоёр том хөрш Хятад, Оросын хооронд ШХАБ дахь ашиг сонирхлын өрсөлдөөн орох бөгөөд Монголын хувьд хоёр том хөршийнхөө өрсөлдөөний аль нэг талд орох бус, тэнцвэртэй харилцахыг эрмэлздэг. Шинэ гишүүн элсэхэд тавих шаардлагын дотор цөмийн зэвсгээс ангид байх асуудлыг оруулах санал гадны шинжээчдийн дунд байдаг бөгөөд хэрэв ийм заалт нэмэгдэж орвол Монгол Улс цөмийн зэвсэггүй статусаа бэхжүүлэх үүднээс ШХАБ-ыг сонирхох бас нэг шижим болох талтайг цухас дурдсан. Дотоод хүчин зүйлсийн дотор Монгол Улс парламентын ардчилалтай улс тул ШХАБ-д нэгдэх асуудлыг улс төрчид, ялангуяа хууль тогтоох эрх мэдэл бүхий парламентын гишүүд санал нэгдсэний үндсэн дээр гаргах ёстой. Гэвч одоогоор улс төрчдийн дунд төдийгүй судлаачдын дотор ч санал зөрөлдөөн байсаар байгаа бөгөөд ард олны дотор ч өнөөгийн нөхцөлд ШХАБ-д элсэх

нь зохимжтой бус гэдэг үзэл ойлголт нэлээд байдгийг онцлон дурдсан. Мөн түүнчлэн Монгол Улс ШХАБ-д элсэхийн тулд хөрөнгө санхүү, боловсон хүчний хувьд сайтар бэхжих хэрэгтэй төдийгүй ОХУ, БНХАУ-аас бусад гишүүн орнуудтой худалдаа, эдийн засаг, хүмүүнлэгийн харилцааг идэвхижүүлэх шаардлагатай. Энэ бол шинэ гишүүн элсэхэд тавьдаг бас нэг чухал шаардлага.

Хурлын үеэр яригдсан нэг чухал сэдэв бол ШХАБ бол нээлттэй, олон улсын аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн байгууллага тул үйл ажиллагаагаа өргөжүүлэх, ялангуяа глобал болон бүс нутгийн ижил төстэй байгууллага, бүтцүүдтэй хамтын ажиллагаагаа идэвхижүүлэх асуудал байв. Сүүлийн жилүүдэд ШХАБ терроризмтой тэмцэх, аюулгүй байдлыг бэхжүүлэх чиглэлээр гадаад хамтын ажиллагааг нэлээд идэвхижүүлж байна. Жишээ нь, 2010 оны 9-р сард Төв Азийн хар тамхи, мансууруулах бодисын худалдаатай тэмцэх мэдээллийн төв /Центральноазиатский региональный информационный координационный центр по борьбе с незаконным оборотом наркотических средств, психотропных веществ и их прекурсоров (ЦАРИКЦ)/-тэй хамтран ажиллах протокол байгуулжээ. Үүний зэрэгцээ НҮБ-ын хар тамхи, гэмт хэргийн асуудал хариуцсан газрын Төв Ази дахь төлөөлөгчийн газар, /Региональное представительство Управления ООН по наркотикам и преступности в Центральной Азии (РП УНП ООН в ЦА)/, НҮБ-ын АЗ-ийн терроризмтой тэмцэх хороо, ТУХН-ийн терроризмтой тэмцэх төв, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага /ОБСЕ/, АСЕАН-ы терроризмтой тэмцэх бүтцүүдтэй хамтын ажиллагаа хөгжүүлж байгаа ажээ.

Афганистаны асуудал. Тус хурлын хамгийн анхаарлын төвд байсан орон бол Афганистан байлаа. Хэдийгээр энэ орон ШХАБ-тай ямар ч холбоо хамаарал байхгүй боловч ойрын үед аюулгүй байдал, геополитик, геоэдийн засгийн ашиг сонирхлын үүднээс тус байгууллагын цаашдын үйл ажиллагаа Афганистаны дотоод гадаад нөхцөл байдалтай нягт уялдаж байна. ШХАБ-ын гишүүн орнуудын анхаарал, сонирхол, эмзэглэлийг төрүүлж буй хоёр гол асуудал бол Афганистан хар тамхины гол суваг, мөн тэнд АНУ, өрнөдийн орнуудын явуулж буй цэрэг дайны үйл ажиллагаа. Дээрээс нь Афганистан эрдэс баялгийн арвин нөөцөө задлаагүй цөөхөн орны нэг тул их гүрнүүд тэнд нөлөөгөө тогтоох ил далд тэмцэл шийтэ шатандаа орж байгаа бололтой. ШХАБ-ын гишүүн орнуудын хувьд хар тамхины урсгалтай тэмцэх үүднээс Афганистанд анхаарал тавих нь хамгийн тулгамдсан асуудал гэж буй боловч цаанаа Афганистаны асуудлыг ямар нэг байдлаар шийдвэрлэн, нөхцөл байдлыг тогтворжуулаагүй цагт АНУ, өрнөдийн нөлөө байр суурийг Төв Азид бууруулах боломжгүй төдийгүй тус орны эрдэс баялагт хүрэх таатай нөхцлийг бүрдүүлж чадахгүй гэдэг нь илүү ач холбогдолтой байж магадгүй юм. Бүс нутгийн терроризмтай тэмцэх бүтцийн Гүйцэтгэх хорооны захирал Ж.Жуманбеков тус хурал ШХАБ-ын орон зайд буй хамгийн гол аюул занал бол Афганистаны нутаг дэвсгэрээс тарж буй хар тамхи бөгөөд үүнийг таслан зогсоохын тулд эрс

шийдвэртэй арга хэмжээг нэн даруй авах хэрэгтэй байна. Тухайлбал, Хөрш зэргэлдээ орнуудын тусгай албад, хүчний байгууллагууд, бизнес, иргэний нийгмийн байгууллагууд бүгд хүч чармайлтаа нэгтгэх замаар хар тамхины урсгалыг таслан зогсоох болон санхүүгийн аюулгүй байдлыг хангах үр нөлөө бүхий хамгаалалтын бүсүүдийг Афганистаны эргэн тойронд байгуулах хэрэгтэй хэмээн мэдэгдэв. Ирэх 6-р сард Астанад болох дээд хэмжээний уулзалтаар ийм бүсүүдийг байгуулах механизм, зарчмуудыг хэлэлцэхээр төлөвлөж буй бололтой. Мөн түүнчлэн Афганы асуудлыг шийдвэрлэхийн тулд 2016 он хүртэл хар тамхины эсрэг тэмцэх стратегийг /"Антинаркотическая стратегия ШОС на 2011-2016 годы"/ гишүүн орнууд Астанад хэлэлцэн батлахаар ажиллаж байгаа ажээ. ШХАБ-ын Ерөнхий НБД М.Иманалиев ч хэлсэн үгэндээ афганы асуудлыг зөвхөн хүч хэрэглэх замаар шийдвэрлэж болохгүй хэмээн цохон тэмдэглэв.

Афганистаны бүс нутгийн судалгааны төвийн захирал Л.А.Гаффур хэлсэн үгэндээ Афганы асуудал богино хугацаанд шийдвэрлэх боломжгүй нарийн төвөгтэйн зэрэгцээ манай асуудлыг шийдвэрлэхэд оролцож буй улс орнуудын үйл ажиллагаанд ямар ч зохицуулалт алга. Нэг хэсэг орон терроризмтой тэмцэнэ гэдэг бол нөгөө хэсэг нь хар тамхины урсгалтай тэмцэнэ гэх, гурав дахь орнууд Афганыг сэргээн босгоход тусална гэх жишээтэй байдаг хэмээн онцлон тэмдэглэж байв. Афганы төлөөлөгчийн гол санаа бол гадаадынхны гол зорилго тодорхойгүй, Афганы талын оролцоо сул, аливаа үйл ажиллагаа саланги тусдаа хүч тарамдсан байвал үр дүн багатай гэдгийг сануулсан бололтой. Энэтхэгийн батлан хамгаалах судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтан М.С.Рой-гийн тавьсан илтгэлийн сэдэв нь Афганистаны асуудал байсан нь /"Афганская проблема и Шанхайская организация сотрудничества: Индийская перспектива"/ бас нэг зүйлийг хэлж байв. Энэтхэг улс Афганистаны бүтээн байгуулалтад оролцох сонирхолтой байгаа бөгөөд зам тээвэр дэд бүтцийн салбарт 1 тэрбум долларын хөрөнгө оруулахад бэлэн байна хэмээн мэдэгдсэн нь Энэтхэгт эдийн засгийн эрэлт хэрэгцээгээ хангах том эрх ашиг буйг илтгэж байна.

ШХАБ дахь Орос, Хятадын нөлөө, өрсөлдөөний асуудал. ШХАБ-ын хамгийн нөлөө бүхий хоёр орон Орос, Хятадын эзлэх байр суурь, нөлөөний асуудал шинэ зүйл биш боловч сүүлийн жилүүдэд тус хоёр орны дэлхийн эдийн засагт гүйцэтгэж буй үүрэг, санхүүгийн хүч нөөцөд гарч буй өөрчлөлтийн улмаас тэдгээрийн Төв Ази дахь эдийн засгийн ашиг сонирхол зөрөлдөх, зөрчилдөх хандлага эрс нэмэгдэж ирэв. ШХАБ-ын хүрээнд хэрэгжүүлэх эдийн засгийн томоохон төслүүд олонтаа хэлэлцэгдэж байгаа боловч түүнд гаргах хөрөнгийн хувь хэмжээ тодорхойгүй, эсвэл санал нийлэхгүйн улмаас цаасан дээр хэвтсээр байна. Оросын судлаач А.Лукин хятадууд эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд идэвхитэй байгаа болон санхүүгийн нөөц ч бэлэн байгааг дурдаад, Хятад хөгжлийн сан болон янз бүрийн хөтөлбөрийг санхүүжүүлэхэд хөрөнгө гаргах талаар ШХАБ-ын бусад орнуудыг хүлээж ядаад өөрийн санаачлагаар 1 тэрбум долларын гаргасан. Гэвч уг хөрөнгийг ашиглахын тулд заавал хятадын

бараа бүтээгдэхүүн авах, хятад компани оролцох асуудал гарч буй тул цаагуураа өнөөх л Хятадын байр суурийг нэмэгдүүлэх асуудал үүсээд байгааг хэлж байв. Хөгжлийн банк байгуулах асуудал дээр аль нэг талын давуу байдлыг олгохгүй байвал төсөл амжилттай болох, Оросын талын тусгай данс нээх санал дэвшүүлсэн бөгөөд үүний тулд Орос, Хятад адил тэнцүү хувь нийлүүлэх, мөн түүнчлэн Энэтхэг сонирхвол тус хоёр оронтой адил үүрэг хариуцлага хүлээх потенциал байгааг ч А.Лукин онцлон тэмдэглэж байв. Казахстаны шинжээч К.Сыроежкин геополитикийн үүднээс авч үзвэл Орос-Хятадын зөрчил нэмэгдэж байна, гэхдээ Хятад аюул занал байхаа больж, гол түнш болж буй нөхцөлд энэ зөрчил явагдаж буйг онцолсон юм. Казахстаны бас нэг судлаач олон улсад ШХАБ-ын аливаа төслийг Хятадын төсөл мэтээр хүлээн авч буй бодит байдлыг сануулж байв. Хятадын төлөөлөгчид эхний өдрийн хуралдаан дээр Хятад-Оросын хооронд ямар ч зөрчил, өрсөлдөөн байхгүй, харилцаа бүх чиглэлээр өндөр түвшинд хөгжиж байна хэмээн зөрчлийг эрс үгүйсгэсэн, нэлээд бухимдангуй байр суурьтай байв. Гэвч төгсгөлийн нэгдсэн хуралдаан дээр Хятадын төлөөлөгчдийн ахлагч, ГХЯ-ы гадаад бодлогын зөвлөлдөх бүлгийн гишүүн Ли Фэнлинь энэхүү хатуу байр сууриа нэлээд өөрчлөн, орос хэл дээр аядуу өнгө аястай үнэлэлт дүгнэлтийн шинжтэй үг хэлсэн юм. Тэрээр энэхүү хурлын үеэр бүтээлч, илэн далангүй хэлэлцүүлэг хийх уур амьсгал бүрдүүлсэн зохион байгуулагч нарын хичээл зүтгэлийг өндөр үнэлж байгаагаа онцлон тэмдэглээд геополитикийн хувьд Хятад, Орос хоёр орон ижил төстэй байр суурь эзэлдэг хэмээн мэдэгдсэн. Тэрбээр бизнесийн өрсөлдөөн, байгалийн хий нийлүүлэх үнэ гэх мэт асуудал дээр санал зөрөх асуудал байж болох тухай өгүүлээд, өрсөлдөөн хөгжлийн хөшүүрэг болох тухай дурдаж байв. ШХАБ шинэ гишүүн элсэх нээлттэй төдийгүй үйл ажиллагааны хувьд нээлттэй байх хэрэгтэй хэмээн хятадын төлөөлөгч нэмж хэлсэн юм. Өмнөх өдөр оросын зарим судлаач ШХАБ-ын гишүүн орнууд бүхий л асуудлаар санал байх албагүй, эдийн засгийн зөрчил улс хоорондын харилцаанд нөлөөлөхгүй явах боломжтой бөгөөд бусад олон улсын байгууллагуудын жишгээр санал нийлж буй асуудлуудаа шийдвэрлээд явах хэрэгтэй гэсэн саналыг дэвшүүлж байв.

Казахстаны Дэлхийн улс төр, эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн захирал С.Акимбеков хоорондоо нягт уялдаатай геополитикийн эмзэг асуудлууд ба аюулгүй байдал, олон улсын хамтын ажиллагааны практик тулгамдсан асуудлууд бол эрдэмтэн судлаачид зайлшгүй анхаарбал зохих маш том судалгааны талбар гэдгийг онцлон тэмдэглэсэн юм. Улс төрчид янз бүрийн шалтгааны улмаас санал бодлоо илэрхийлж чаддаггүй тийм нарийн төвөгтэй асуудлуудаар шинжээчид эрдэмтэд хэлэлцүүлэг явуулж чаддаг бөгөөд үүний тулд эрдэм шинжилгээний дипломат бодлого үйлчилж байна. Энэ удаагийн хурал ч ийм зорилготой гэдгийг онцлон тэмдэглэж байв. Гэвч Аль-Фарабийн нэрэмжит Казахстаны үндэсний их сургуулийн багш Сайфулла Сапанов “Проблемы прав человека в рамках ШОС: геополитический аспект”

нэртэй илтгэлдээ Хятадад хүний эрх ихээхэн зөрчигдөж буй талаар жишээ баримт татан шүүмжилсэн нь зохион байгуулагчдыг нэлээд сандаргаад авсан явдал болов.

ШХАБ-ын бүтэц, зохион байгуулалт, төсвийн асуудал. Хуралд оролцсон хүмүүсийн зүгээс ШХАБ-ын бүтэц, зохион байгуулалт, төсөв, үйл ажиллагааны бие даасан байдал зэргийг нэлээд өөрчлөн шинэчлэх, НҮБ, ЕХ, АСЕАН маягаар зохион байгуулах саналыг дэвшүүлж байв. Тухайлбал А.Лукин ШХАБ-ын НБДГ-ын үйл ажиллагаа учир дутагдалтай, гишүүн орнуудын төлөөлөл төдий байгааг шүүмжлээд, төсөв ердөө 4 сая доллар байгаа нь бие даасан үйл ажиллагаа явуулахад хангалтгүй хэмээн үзэж байв. Тэрбээр НҮБ хэдийгээр гишүүн орнуудын төлөөлөлтэй боловч ажилтнуудаа сонгон шалгаруулж авдаг, үйл ажиллагаа нь ч өөрийн зарчим, дэг журмын дагуу харьцангуй бие даасан байдлаар явуулдаг сайн жишээ байгааг онцлон дурдаж байв. Хуралд оролцсон хүмүүс ШХАБ цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэхтэй уялдан хууль эрх, төсөв санхүүтэй дүрэм журам шинээр батлагдан, хэрэгжиж эхлэх үед нэлээд олон асуудал, түүний дотор байгууллагын төсөвт гишүүн орнууд ямар хувь хэмжээ, квоттой байх асуудал тодорхой болно хэмээн найдаж байна.

ШХАБ-ыг даргалж буй орны хувьд Казахстан улс ШХАБ байгуулагдсаны 10 жилийн ойн хүрээнд Астана хотноо болох дээд хэмжээний уулзалтыг өндөр түвшинд зохион байгуулах, түүний үр өгөөж, үр дүнг нэмэгдүүлэхийн тулд ихээхэн хүчин чармайлт гаргаж буйн илрэл нь энэхүү эрдэм шинжилгээний хурал боллоо.

Бэлтгэсэн Д. Шүрхүү